




ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН АРДЧИЛСАН
НАМЫН ХОРОО
Утас 91020912,99977620

2022.4.12 № 03.
Танай _____ 1 _____

Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.8 дах хэсэг мөн, хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивийн тайланд дүгнэлт гаргуулахаар хүргүүллээ.

Хавсралт:

ДЭД ДАРГА  ГОТГОНБАЯР



D. Баланк /А-5

**Батноров сумын Ардчилсан намын 2022 оны сумын ИТХ-ын нөхөн
сонгуульд дэвшүүлж буй мөрийн хөтөлбөр
2022 он**

1.ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ

/Боловсрол, эрүүл мэндийн төгс үйлчилгээ, өрх гэр бүл, хүүхэд, нийгмийн хамгаалал, аялал жуулчлал, спорт урлаг, ХӨГЖЛИЙГ ХҮРТЭХ БАТНОРОВ-ХӨГЖЛИЙГ ХҮН БҮРТ, ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ

- 1.Хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, нутаг орныхоо байгаль, түүх, соёл, уламжлалаараа бахархдаг “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2."Батноровын ирээдүй-Багшийн хөгжил" хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж багш нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлж давтан сургах ажлыг үе шаттай зохион байгуулна.
- 3.Сургууль цэцэрлэгийн удирдах албан албан тушаалтныг чөлөөлөх, томилоход сумын иргэдийн төлөөллөөс бүрдсэн "Боловсролын зөвлөл"-ийн саналыг харгалзана.
- 4.Өндөр хөгжилтэй оронд орон нутгийн, сум бүрийн бодлого захиалгын дагуу оюутан болон албан хаагчдыг сургаж мэргэшүүлнэ.
- 5.Орон нутгийн үйлдвэрлэлийн бодлоготой уялдуулан зах зээлийн хэрэгцээнд нийцсэн нарийн мэргэжлийн болвсон хүчнийг аймгийн МСҮТ-д бэлтгэнэ.
- 6.Суманд 230 хүүхдийн багтаамж бүхий цэцэрлэгийг шинээр ашиглалтанд оруулна.
- 7.Хүүхдийг цахим мэдээллийн халдлагаас хамгаалах "Зөв дархлаа" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 8.Урьдчилсан сэргийлэх үзлэгт суурилсан өндөр үр өгөөж бүхий эрүүл мэндийн тогтолцоог орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлнэ.
- 9.Орон нутгийн эмч нарыг өндөр хөгжилтэй газруудад явуулж туршлагыг эзэмшүүлэн мэргэшүүлэх замаар хорт хавдрын эрт илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний чанарыг улсын түвшинд хүргэнэ.
- 10.Сумын эрүүл мэндийн төвийн залуу эмч нарын мэргэжил боловсролыг хоёр жил тутамд дээшлүүлэх, сувилагч нарыг дээд сургуульд / бакалавр/ суралцахыг бодлогоор дэмжинэ.

11. Сумдын эрүүл мэндийн төвүүдийн барилгад их засвар хийнэ.
12. Эрүүл мэндийн салбарын эм хангамж, хүний нөөц, удирдлага менежментийн талаар орон нутагт тохирсон алсын хараатай бодлого хэрэгжүүлнэ.
13. Сумын нутаг дэвсгэрт байгаа эмчилгээний чанартай рашаан ус, ургамлыг орон нутгийн хамгаалалтад авч эзэнжүүлэн Уламжлалт анагаах ухааны өв санд суурилсан үйлчилгээний брэнд бүтээгдэхүүн, эмийн найрлагад ордог ургамал, эрдсийн нөөцийг тарималжуулж үржүүлэхийг бодлогоор дэмжинэ.
14. Тэтгэвэр тогтоолгосон ахмад эмч нарыг эрүүл мэндийн байгууллагад "Зөвлөх"-өөр ажиллуулахыг орон нутгийн түвшинд шийдвэрлэнэ.
15. Яаралтай түргэн тусламжийн үйлчилгээний зохион байгуулалтыг шинэчилж, үйлчилгээний чанар, хүртээмж шуурхай байдлыг эрс сайжруулна.
16. Сумын эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэгчдийн бүртгэл дарааллын дугаарыг цахимаар авдаг болгож тус салбарт ажиллагсдад хариуцлага ё зүйг дээшлүүлэх арга зүйг боловсруулан хэрэгжүүлнэ.
17. "Архигүй Хэнтийчүүд-2" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
18. Батноров сумын иргэн бүрийг үндэсний хэл, соёл, ёс уламжлалаа эрхэмлэдэг төлөвшөлтэй болгоход зориулан "Оюунлаг Хэнтийчүүд" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
19. Аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаад дотоодын жуулчлыг татах, орон нутаг, өв соёлоо сурталчлах зорилгоор Эвент арга хэмжээг жил бүр зохион байгуулна. /Талын түмэн адуу/
20. Нутаг орныхоо нэрийг тив, дэлхий, улсад өндөрт өргөсөн тамирчид, уран бүтээлчид, эрдэмтэд, алдартнуудыг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.

**ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ / Жижиг дунд бизнес,
Хөдөлмөрийн зах зээл, Аж үйлдвэрлэлийн салбар, Дэд бүтэц, Эрчим
хүч, Барилгын салбар, Шинжлэх ухаан технологи, Аялал жуулчлал/
ӨСӨЛТИЙГ БҮТЭЭГЧ ХЭНТИЙЧҮҮД /ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ/**

1. Сумын гадаад харилцааны бодлогын үндсэн дээр эдийн засгийн түншлэл, худалдааны хэлэлцээрүүдийг хийх бодлого баримтална.
2. Малын гаралтай түүхий эд, арьс ширний болон дайвар бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн болгох сум дундын үйлдвэрийг бодлогоор дэмжин байгуулна.

ЧУВА

2317
СЮА004

3. Суманд өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор төмс хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэлийг дэмжсэн хөтөлбөр хэрэгжүүлж хүлэмж, агуулах, зоориудын барьж байгуулна.
4. Иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр ажиллах нөхцөлийг журамлаж гарал үүслийн гэрчилгээ олгох замаар дундын зуучлагч, ченжүүдийн хараанд орохоос урьдчилан сэргийлнэ.
5. Өндөр хурдны интернэтийн сүлжээг өргөтгөж, 5G технологийг нэвтрүүлнэ.
6. Банкны үйлчилгээг нэмэгдүүлж Интернэт банк-АТМ ийг суманд шинээр байршуулах.

**ГУРАВ. ЭЗЭН МОНГОЛ / Орон нутгийн хөгжил, Шинэ сум, Бэлчээр,
Газар тариалан/
НУТАГТАА ЭЗЭН ХЭНТИЙЧҮҮД**

1. Орон нутгийн хөгжлийн санг иргэдийн оролцоотой дүгнүүлдэг, үр ашигтай, хэмнэлттэй төсөв, аудит хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.
2. Сэргээгдэх эрчим хүчийг ашигласан усжуулалтын систем, худгийг өргөнөөр ашиглах боломжийг бүрдүүлнэ.
3. Малчдын хамтын оролцоонд тулгуурлан бэлчээрийн зохистой менежментийг боловсруулан баталж хэрэгжүүлж эхэлнэ.
4. Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежментийг иргэд малчдад таниулснаар газар нутгийнхаа ан амьтан, ургамал, байгалийн дагалт баялаг нь өөрийн эзэнтэй болох нөхцлийг бүрдүүлнэ.
5. Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд өнгөт чулууг олборлон түүх, байгалын дагалт баялагуудыг зөвшөөрөлгүй бэлтгэх зэрэг зөрчлийг арилгахад зориулан тусгай журам боловсруулж аймгийн ИТХурлаар баталгаажуулан мөрдүүлнэ.
6. Сумын хилийн цэсийг тодотгон баталгаажуулах ажлыг хэрэгжүүлнэ.
7. Орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалтыг сайжруулсанаар жижиг дунд бизнес эрхлэгчдийг ажлын байраар хангана.
8. Мах махан бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх хяналтын горимыг сайжруулан малыг эрүүлжүүлэх ухаалаг хяналтын системийг нэвтрүүлнэ.

14297
9074882

**ДӨРӨВ. ХУУЛЬТАЙ МОНГОЛ/ Иргэнээ хамгаалдаг хууль,
ХУУЛИЙГ ДЭЭДЛЭГЧ БАТНОРОВЧУУД**

1. Авилга, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, нийтийн албаны үйл ажиллагааг иргэдэд ил тод, ялгамжгүй, шударга, хүртээмжтэй хүнд сурталгүй хүргэнэ.
2. Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих ажлыг эрчимжүүлж архидалт согтуурлын хор хөнөөлийг бууруулах ажлыг идэвхижүүлэнэ.

ТАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН МОНГОЛ / Байгаль орчин, ногоон хөгжил /

1. Ойжуулах, ойг цэвэрлэх, нөхөн сэргээх асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, шинэ технологи нэвтрүүлнэ.
2. Суманд "Ногоон гудамж", "Иргэн бүр-Нэг мод" төслүүдийг хэрэгжүүлэн үр дүнгээр нь урамшуулах ажлыг жил бүр хийнэ.

Өсөлтийг өрх бүрт